

Уриа: Төрөө төвшитгөж,  
түмэн олноороо амгалан байцгаах  
үндэсний их үйлсэд нэгдэцгээе !



---

# ЭЛГЭН ОЛНООРОО НЭГДЭЖ ТӨРӨӨ ТӨВШИН АМГАЛАН ТӨРӨЛ ОЛНОО ЭНХ АМГАЛАН БОЛГОЦГООЁ.

---

*Хүн нар маань мандан бадарч энх цагаа эхлүүлэн, таалан таашааж талархал  
дүүрэн байг.*



ШАРНУУД ОВОГТОЙ ДОРЖСҮРЭНГИЙН ЭНХ-АМГАЛАНГИЙН

МӨРИЙН ХӨТӨЛБӨР.

2024-05-07

**МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД,  
МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН  
ТАВДУГААР ЗҮЙЛИЙН  
ГУРАВТ ЗААСАН ЭРХИЙН ДАГУУ 9-Р ТОЙРОГТ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
УДИРДАХ УХААНЫ ДОКТОРАНТ,  
ДОРЖСҮРЭНГИЙН ЭНХ-АМГАЛАНГИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**НИЙГМИЙН БОДЛОГЫН ХӨТӨЛБӨР**

1. Үрс, хүүхдүүдийнхээ төлөө Баянгол дүүрэгтээ цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж байгуулах ажлыг дэмжиж ажиллана.
2. Хүн бүрд ээлтэй хүнлэг, хүндээ чиглэсэн боловсролын тогтолцоог бий болгоно.
3. Үндэсний 3 тулгуурт үзлийг сэргээж, үндэсний баримтлах бодлогын суурь үзэл болгоно.
4. Олноо амар амгалан байлгахын төлөө Үндэсний их завсарлага, Нэгнээ уужиртал сонсоцгооё, Уужуу ухаантай Монгол гэсэн бүх нийтийн аянг зохион байгуулна.
5. Удирдах ухаанд шинэ салхи оруулж Агуу Их Эзэн Хаадынхаа улсаа жолоодох ухааныг олж, аргачлалыг бий болгож, төрөө засаж цаашлан даян дэлхийн удирдагч нарт түгээн дэлгэрүүлнэ.
6. Шинжлэх ухаанд суурилсан учир шалтгааны төвийг байгуулах, шинжлэх ухааны суурь баазыг бий болгож үйл ажиллагааг нь дэлгэрүүлж ажиллана.
7. Өвөг дээдэстээ итгэж, хүлээн зөвшөөрч бодит амьдарлын жам мөрөөр хүн төрөлхтөнөө хөтөлнө.
8. Үндэсний нэгдлийн индексийг бий болгож улсаа шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нэтгэж, уг нэгдлийн онол, ойлголтыг гадаадад экспортлоно.
9. Эх хэлээр утга төгөлдөр өгүүлэхийг эрхэм болгох бодлого боловсруулж ажиллана.
10. Хүнлэг нийгмийг цогцлоох суурь, бодлогын бичиг баримтыг боловсруулж аргачлал болон зөвлөмжийг бий болгож ажиллана.
11. Жендерийн ба хүйсийн тэгш эрхийн шийдлийг өөрсдийн уламжлалт ойлголтоор бүрэн цэгцэлж, цаашид НҮБ-тай хамтран дэлхийн улс орны удирдагчидад үлгэр болгон хэрэгжүүлэх аргачлал болон зааварчилгааг боловсруулж, дэлхий дахинаа дэлгэрүүлнэ.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

1. Газрын талаар баримтлах бодлогыг хэрхэн нэг мөр бүхэнд ач тустай байх суурь судалгааг хийж, аргачлалыг боловсруулж ажиллана.
2. Мал аж ахуйн салбарт Ойн зурвас бий болгож, хүнээ малтайгаа аварч, нутгийн унаган өвс ургамлыг нөхөн сэргээх төслийн үр ашгийн тооцооллыг судлан гаргаж хэрэгжүүлэх боломжит нөхцөлийг бүрдүүлэх, улмаар уламжлалт мал аж ахуйгаа аварна.

#### БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТ НИЙТИЙН БИЕЙН

##### ТАМИРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

1. Уламжлалт хүнээр хүн хийх ойлголтыг олж тогтоон бүх шатны боловсролын байгууллагад сургалт, үйл ажиллагаанд нэвтрүүлж ажиллана.
2. Бие, сэтгэл, оюуны боловсролын агуулга, загварыг бий болгож олноо түгээнэ.
3. Сургуулийн сургалтын үнэлгээ, багачуудын оюунд үзүүлж буй сөрөг нөлөөлөл болон ирээдүйн амьдралд нь нөлөөлөх магадлалыг судалж тогтоон, сургалтын үнэлгээнд шинэчлэл хийнэ.
4. 8, 10 жил болон 12 жил суралцах боломжийг ЕБС-д бий болгох суурь судалгаа болон аргачлал, зөвлөмжийг бий болгоно.
5. Бүх шатны сургалтын агуулга болон хөтөлбөрт 51 хүртлэх хувийг үндэсний үзэлд тулгуурласан, хүн, амьтан, ургамал болон байгалд ээлтэй эрин өртөөлөх, өгөөжтэй хөтөлбөр болгож өөрчилнө.
6. Монгол ухаан, үндэсний гүн ухаан өв, соёл, жам, ёс, уламжлал, амьдрах арга эрдмийг багтаасан жишиг сургуулийн загварыг бий болгож цаашид хөдөөгийн сургуулиудын агуулгад нэвтрүүлнэ.
7. Шинжлэх ухаанд үндэсний УХААН гэх ойлголтыг нэвтрүүлж томоохон байр суурь эзлэх бүтцийг бий болгох талаар Шинжлэх Ухааны Академитай хамтран судалгаа хийж, олж тогтоон, аргачлал боловсруулж хамтран ажиллана.
8. Нийтийн орон сууцанд амьдрах хүмүүсийн эрүүл мэнд, биеийн тамир спортыг нь дэмжих зорилгоор Падел Теннисийг улс орон даяар дэлгэрүүлнэ.

##### УЛСТӨР, ТӨРИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

1. Хүнлэг нийгмийн манлайлагчдыг бий болгоно.
2. Төр төвшитгөх уламжлалт ухаан, ёсыг судлан, олж тогтоож төрөө төвшитгөнө.
3. Уламжлалт төрийн загварт авилгагүй төр байсанг олж тогтоох судалгааны ажлыг эхлүүлж, тэрхүү төрийн загвараар төрөө цэгцлэж авилгагүй, тогтвортой төрийн аргачлал, заавар боловсруулж нэвтрүүлнэ.

##### ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

1. Хүнлэг эдийн засгийн бодлогыг олж тогтоох, бүтцийг бий болгох боломжийн талаарх суурь судалгааг хийж, гадаадаас дотогш чиглэсэн мөнгөний урсгалыг нэмэгдүүлэх талаар илүүтэй анхаарч дэмжиж ажиллана.

2. Эдийн засаг хүний амьдарлын хувьд ямар байр суурь эзлэх нь зүйтэй талаар бодит байдалд суурилсан суурь судалгааг хийнэ.
3. Аялал жуулчлалын салбарт байгальд ээлтэй аялал жуулчлалын загварыг гаргаж хэрэгжүүлэх талаар судлан, чанарт суурилсан аялал жуулчлалын судалгааг хийж чиг хандлагыг тодорхойлно.
4. Үндэсний оюуны экспортын биет болон хийсвэр бүтээгдэхүүнийг олж тогтоож, хөгжүүлэн дэлхийн зах зээлд экспортлож дэлхийн зах зээлд нийлүүлэх нэг цэгийн үйлчилгээг эхлүүлэх боломжийн суурь судалгааг хийж гүйцэтгэнэ.
5. Уламжлалаа дээдлэн, дагаж, сахиж, эрхэмлэн, тээж яваа хүмүүсээ хэрхэн бодитоор урамшуулж болох талаарх хийж, үр дүнд нь суурилсан аргачлал болон зөвлөмжийг бий болгож, холбогдох бодлогын бичиг баримтад тусгана.
6. Экспортын гарцыг нэмэгдүүлэх чиглэлээр дэмжиж ажиллана.
7. 100 хувь бие даасан эрчим хүчээр өөрийгөө бүрэн хангасан улс болох бодлогыг бүх талаар дэмжиж ажиллана.
8. Уламжлалаа дээдлэн, сахиж яваа хүмүүсийг урамшуулан дэмжих тогтолцоог бий болгоно.
9. Жилийн 500 сая төгрөгийн хүртлэх орлогтой хүмүүст татварын чөлөөлөлт, хөнгөлөлтөд хамрагдах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

#### ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН ХҮРЭЭНД.

1. Хүнлэг нийгмийн харилцаанд суурилсан гадаад хамтын ажиллагааны бодлогын бичиг баримтыг бий болгож дэлхийн улс орны удирдагчдаар хүлээн зөвшөөрүүлнэ.
2. Дотооддоо бүрэн ойлголцох эв эеийн нэгдмэл ойлголтын бодлогын баримтыг бий болгож олноор хүлээн зөвшөөрүүлж чандлан сахихад олноо уриална.
3. Олноор хэрхэн оюунаараа гадаад зах зээлээс мөнгө оруулж ирж болох судалгаа хийх баталгаажсан хамтын ажиллагааны загварчлал бий болгох хамгийн өгөөжтэйг бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхийг дэмжинэ.

#### ЭДГЭХ УХААН БА БҮХ НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХҮРЭЭНД.

1. Хүнлэг нийгмийн бодлогын баримт бичгийг боловсруулж, үүнд үндэслэн хүнлэг анагаах ухааныг бий болгож түгээн дэлгэрүүлнэ.
2. Монгол хэлний чиглэлийн эрдэмтэн мэргэдтэй хамтран зарим түгээмэл хэрэглэгдэх үгийн орчуулгыг засах, үг хүний оюунд хэрхэн хүрч хэрхэн тухайн нэгнийг үйлд нөлөөлдөг болох талаар нарийвчилсан судалгаа хийх цаашид хэрхэн хүн төрөлтөнөө тустайгаар өгүүлэх талаар аргачлал боловсруулж, зөвлөмж хүргүүлнэ.
3. Гурван тулгуурт үзэл ба гал, ус, хий үзэлд суурилсан эдгээх ухаан Дөрвөн тулгуурт үзэл ба гал, ус, хий, шороо үзэлд суурилсан анагаах ухаан Таван тулгуурт үзэлд суурилсан ба гал, ус, төмөр, шороо, мод тулгуурт үзэлд суурилсан анагаах ухааны аль нь манайх, аль нь харийнх болох, манай танайгаа ялгаж мэдэх ач тус, өгөөжийн талаар нэгдсэн ойлголттой болох

- улмаар хүндээ итгэх итгэлд суурилсан анагаах ухааныг бий болгох, дэлгэрүүлнэ.
4. Хүний төв удирдлагын талаар болон хүн төрөлхтөний байгалийн үйл ажиллагааны талаар анагаах ухааны хүн нэрт биес бүрд гүн ухааны үүднээс таниулах, цаашид хүндээ итгэх итгэлд суурилсан зөвлөгөө өгөх талаар эрхэмлэн сахих талаар аргачлал боловсруулж, зөвлөмж гаргана.
  5. Өвчин, өвдөх, үхэл ба зовлон гэж чухам юу болох талаар Монгол хэлний эрдэмтэн, мэргэд, судлаачидтай хамтран судлаж нэгдсэн нэг ойлголттой болж улмаар ард олноо түгээх талаар аргачлал бий болгож зөвлөмж гарган олноо түгээн дэлгэрүүлнэ.
  6. Хүний биеийн байгалийн үйл ажиллагааны төгс горимын талаар судалгаа хийж, баталгаажуулж, түгээн дэлгэрүүлнэ.
  7. Гурван тулгуурт үзэлд суурилсан эдгэх ухааныг улам бүр дэлгэрүүлж дэлхийн хамгийн их түгээмэл эдгэх ухаан болгож хүн төрөлтөний анагаах ухааны салбарт тэргүүлэх байр суурийг эзэлж, толгойлно.
  8. Үндэсний оюун түлхүүр ухаанд суурилсан эдгэх ухааныг олж нээнэ.
  9. Өнөөг хүртэл тээж байгаа хүн нарын үндэсний эдгэх ухааны арга ухааныг хөдөө мал дагаж уламжлалаа дээдлэн оршиж байгаа хүн нараас олж илрүүлж түгээмэл нүүдэлчдийн эдгэх ухааны загварчлалыг бий болгоно.
  10. Барууны ба өрнийн анагаах ухаанаас болон Дорнын 5 тулгуурт үзлийн анагаах ухаанаас манайд зайлшгүй байх ач тустай олж тогтоон түүнийг нутагшуулахад итгэл дээр суурилсан эдгэх ухааны үзэл баримтлалд суурилсан хөтөлбөрөөр өөрийн болгоно. Улмаар харийн хэнээс ч хамааралгүй бие даан хөгжих бүх нөхцлийг бий болгоно.
  11. Пласибо эффектийн судалгааны хүрээлэнг бий болгох, өөрийн үндэсний эдгэх ухааны суурьтай холбож, судлан тогтоож, өөрийн болгож дэлхийн хүн төрөлтөнд түгээх шинэ боломжит зах зээлийг бий болгоно.
  12. Цогц эдгэх ухааны талаар өөрийн үндэсний эдгэх ухааны өвд суурилсан мэдлэгт суурилсан аргачлалыг бий болгож, дэлхийн хүн төрөлтөнд түгээн дэлгэрүүлнэ.
  13. Өөрийн үндэсний, уламжлалт ухаанд суурилсан плацебо эмийн бүтээгдэхүүнийг бий болгож, үйлдвэр байгуулан дэлхийн хүн төрөлтөнд бүтээгдэхүүнээ хүргэнэ.

Өөрийн мөрийн хөтөлбөрөө биелүүлж бодит үйл хэрэг болгоно.

Олноо өргөж буй өөрийн мөрийн хөтөлбөрөө хичээгүйлэн, оюундаа тунгаан уламжлалт өвөг дээдсийн ухаантай хослуулан боловсруулсан:

Улсын Их Хурлын Сонгуулийн 9-р тойрогт бие даан нэр дэвшигч

**Удирдах ухааны Докторант, Доржсүрэнгийн Энх-Амгалан.**

**Боловсруулахад эх сурвалж болгон ашигласан баримтууд:**

- ✓ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Тухай хууль
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ 2050 Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хөтөлбөр
- ✓ Баянгол дүүрэг “Хүн ам зүй, шилжилт хөдөлгөөн ба хэрэгцээ шаардлага” түргэвчилсэн судалгаа 2022 оны 6 сар
- ✓ Баянгол дүүргийн нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл
- ✓ Баянгол дүүргийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
- ✓ Баянгол дүүргийн ЗДТГ алсын хараа, эрхэм зорилго
- ✓ Баянгол дүүргийн хүн амын тоон баримт /хороогоор/ 2023-2024
  - ✓ Баянгол дүүргийн албан ёсны цахим хуудас: <http://www.bgd.mn/>